



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАНГАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/319/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Ц.Хосжаргал

Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn

Ахлах аудитор Л.Нямтөмөр

Утас: 261740 Цахим хаяг: nyamtumurl@audit.gov.mn

Аудитор С.Бат-Эрдэнэ

Утас: 261740 Цахим хаяг: bat-erdenes@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа	14
4.2 Албан шаардлага	14
4.3 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХҮТ	Хангалт үйлчилгээний төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХАНГАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА А.ЭНХБАТ ТАНАА

2022.02.24 № 07/305
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,768,380,724.34	6,800,912,276.08
33	АВЛАГА	4,924,869.10	5,594,685.10
33500	Бусад авлага	4,924,869.10	5,594,685.10
33510	Байгууллагаас авах авлага	4,924,869.10	5,594,685.10
35	БАРАА МАТЕРИАЛ	6,763,455,855.24	6,795,317,590.98
35100	Түүхий эд материал	472,183,039.48	281,737,666.56
35110	Тусгай зориулалттай материал	472,183,039.48	281,737,666.56
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,455,287,684.67	4,525,545,979.16
35400	Хангамжийн материал	1,835,985,131.09	1,988,033,945.26
35410	Бичиг хэргийн материал	14,046,285.00	8,085,435.00
35420	Аж ахуйн материал	41,635,651.54	38,588,760.04
35450	Барилгын засварын материал	12,216,635.00	17,873,575.00
35460	Хүнсний материал	0	4,680,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,768,086,559.55	1,918,806,175.22
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,511,626,824.77	1,394,709,078.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,511,626,824.77	1,394,709,078.86
39200	Биет хөрөнгө	1,415,009,209.80	1,312,716,990.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,294,079,841.00	1,294,079,841.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(163,476,743.95)	(232,923,745.95)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	216,277,307.76	216,285,266.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	(83,054,674.65)	(98,220,649.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,474,279.60	16,647,884.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,904,240.53)	(13,071,764.34)
39214	Бусад үндсэн хөрөнгө	171,189,646.83	169,218,066.83
39215	Хуримтлагдсан элэгдэл	(25,576,206.26)	(39,297,909.06)
39300	Биет бус хөрөнгө	96,617,614.97	81,992,088.33
39301	Програм хангамж	17,920,000.00	15,920,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,985,625.03)	(7,519,791.67)
39303	Бусад биет бус хөрөнгө	83,683,240.00	73,591,880.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,280,007,549.11	8,195,621,354.94
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,280,007,549.11	8,195,621,354.94
51	Засгийн газрын хувь оролцоо	8,280,007,549.11	8,195,621,354.94
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	712,798,653.67	702,707,293.67
51200	Хуримтлагдсан үр дүн	6,445,442,629.37	6,371,147,795.20
51210	Өмнөх үеийн үр дүн	6,783,522,317.70	6,445,442,629.37
51220	Тайлант үеийн үр дүн	(338,079,688.33)	(74,294,834.17)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,121,766,266.07	1,121,766,266.07
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,280,007,549.11	8,195,621,354.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,530,379,531.50	11,020,090,755.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,743,457,004.50	10,313,183,051.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,743,457,004.50	10,313,183,051.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	301,015,974.82	374,772,521.43
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	123,304,098.38	115,260,560.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	176,990,769.44	254,835,960.93
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	721,107.00	4,676,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	111,875,727.50	14,990,422.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	10,330,565,302.18	9,923,420,107.57
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	786,922,527.00	706,907,704.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	762,508,000.00	657,847,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	762,508,000.00	657,847,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,414,527.00	49,059,804.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,414,527.00	49,059,804.70
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,807,181,923.60	7,917,231,247.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,807,181,923.60	7,917,231,247.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,786,205,984.16	7,779,400,370.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	673,381,822.94	510,444,837.00
210101	Үндсэн цалин	555,150,822.94	336,120,337.00
210102	Нэмэгдэл	118,231,000.00	174,324,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,912,519.00	19,416,279.00
210201	Тэтгэврийн даатгал	23,251,608.00	7,693,506.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,696,570.00	850,977.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,118,213.00	680,777.00
210204	Ажилгүйдлийн даатгал	480,987.00	163,133.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,365,141.00	10,027,886.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,513,232.00	15,623,152.55
210301	Гэрэл, цахилгаан	12,513,232.00	12,141,727.90
210302	Түлш, халаалт	0	3,481,424.65
2104	Хангамж, бараа материалын зардал	31,640,892.15	59,790,961.50
210401	Бичиг хэрэг	22,477,990.00	40,612,820.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,070,000.00	1,070,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,613,196.00	660,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,226,886.15	7,831,250.00
210408	Бараа материал акалсны зардал	252,820.00	9,616,891.50
2105	Норматив зардал	6,822,950,539.46	6,818,026,280.98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	150,000.00
210502	Хоол, хүнс	2,750,650.00	7,184,980.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,820,049,889.46	6,810,691,300.98

**Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	81,622,562.00	89,637,420.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	1,129,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	55,787,862.00	66,664,660.00
210604	Урсгал засвар	25,834,700.00	21,843,060.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,516,289.00	126,739,632.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	123,060,632.00
210807	Газрын төлбөр	3,016,289.00	3,679,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	119,668,127.61	139,721,807.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	819,000.00	13,229,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	118,849,127.61	126,492,807.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,975,939.44	137,830,876.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	980,000.00	4,320,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	980,000.00	4,320,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,995,939.44	133,510,876.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,995,939.44	133,510,876.46
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,723,197,607.90	3,102,859,508.30
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,061,277,296.23	3,177,154,342.47
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	4,061,277,296.23	3,177,154,342.47
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(338,079,688.33)	(74,294,834.17)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	712,798,653.67	1,121,766,266.07	6,783,522,317.70	8,618,087,237.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	712,798,653.67	1,121,766,266.07	6,783,522,317.70	8,618,087,237.44
Тайлант үеийн үр дүн			(338,079,688.33)	(338,079,688.33)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	712,798,653.67	1,121,766,266.07	6,445,442,629.37	8,280,007,549.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	712,798,653.67	1,121,766,266.07	6,445,442,629.37	8,280,007,549.11
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(10,091,360.00)			(10,091,360.00)
Тайлант үеийн үр дүн			(74,294,834.17)	(74,294,834.17)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	702,707,293.67	1,121,766,266.07	6,371,147,795.20	8,195,621,354.94

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	910,226,625.38	882,416,161.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	123,304,098.38	175,508,456.31
120	Нийтлэг татварын бус орлого	123,304,098.38	175,508,456.31
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	123,304,098.38	175,508,456.31
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	123,304,098.38	175,508,456.31
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	786,922,527.00	706,907,704.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	762,508,000.00	657,847,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	762,508,000.00	657,847,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,414,527.00	49,059,804.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,414,527.00	49,059,804.70
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	910,226,625.38	833,356,356.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	910,226,625.38	833,356,356.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	889,250,685.94	694,625,479.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	673,447,545.94	515,223,837.00
210101	Үндсэн цалин	555,216,545.94	340,899,337.00
210102	Нэмэгдэл	118,231,000.00	174,324,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,846,796.00	19,416,279.00
210205	Эрүүл мэндийн даатгал	40,846,796.00	19,416,279.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,513,232.00	23,648,968.55
210301	Гэрэл, цахилгаан	12,513,232.00	16,499,543.90
2104	Хангамж, бараа материалын зардал	97,120,396.00	95,167,600.00
210401	Бичиг хэрэг	87,703,200.00	87,703,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,684,000.00	-
210404	Ном, хэвлэл	120,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,613,196.00	660,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	6,804,400.00
2105	Норматив зардал	2,650,000.00	4,115,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	150,000.00
210502	Хоол, хүнс	2,500,000.00	2,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,750,000.00	32,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,750,000.00	-
210604	Урсгал засвар	30,000,000.00	27,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,930,816.00	4,928,195.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,914,527.00	1,249,195.30
210807	Газрын төлбөр	3,016,289.00	3,679,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,991,900.00	125,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,616,600.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	375,300.00	125,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,975,939.44	138,730,876.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	980,000.00	5,220,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	980,000.00	4,720,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,995,939.44	133,510,876.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,995,939.44	133,510,876.46

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	49,059,804.70
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	49,059,804.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	49,059,804.70
2200	Дотоод эх үүсвэрээр	-	49,059,804.70
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(49,059,804.70)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	699,847,900.00	699,845,479.85	2,420.15	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	699,847,900.00	699,845,479.85	2,420.15	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	694,627,900.00	694,625,479.85	2,420.15	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	515,224,000.00	515,223,837.00	163.00	100.0
210101	Үндсэн цалин	340,899,500.00	340,899,337.00	163.00	100.0
210102	Нэмэгдэл цалин	174,324,500.00	174,324,500.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,416,700.00	19,416,279.00	421.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,416,700.00	19,416,279.00	421.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,650,000.00	23,648,968.55	1,031.45	100.0
210301	Гэрэл, цахилгаан	16,500,000.00	16,499,543.90	456.10	100.0
210302	Түлш, халаалт	7,150,000.00	7,149,424.65	575.35	99.9
2104	Хангамж, бараа материалын зардал	95,167,600.00	95,167,600.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	87,703,200.00	87,703,200.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	660,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,804,400.00	6,804,400.00	-	100.0
2105	Норматив зардал	4,115,600.00	4,115,600.00	-	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	150,000.00	-	100.0
210502	Хоол, хүнс	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,465,600.00	1,465,600.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,000,000.00	32,000,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	4,500,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	27,500,000.00	27,500,000.00	-	100.0

**Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,929,000.00	4,928,195.30	804.70	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,250,000.00	1,249,195.30	804.70	99.9
210807	Газрын төлбөр	3,679,000.00	3,679,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	125,000.00	125,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	125,000.00	125,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,220,000.00	5,220,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,220,000.00	5,220,000.00	-	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,720,000.00	4,720,000.00	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	699,847,900.00	699,845,479.85	2,420.15	100.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	657,847,900.00	524,337,023.54	133,510,876.46	79.7
310001	Улсын төсвөөс санхүүжих	657,847,900.00	524,337,023.54	133,510,876.46	79.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	42,000,000.00	175,508,456.31	(133,508,456.31)	417.8
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,000,000.00	175,508,456.31	(133,508,456.31)	417.8
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	40	41	-1	102.3
620001	Удирдах ажилтан	1	1	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	39	40	-1	102.3

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	49,059,804.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	49,059,804.70
2200	Дотоод эх үүсвэрээр	-	49,059,804.70
222001	Тоног төхөөрөмж	-	49,059,804.70
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	49,059,804.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	49,059,804.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	49,059,804.70

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төлбөр тооцоог барагдуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-наас 2022 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн хооронд Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Л.Нямтөмөр, аудитор С.Бат-Эрдэнэ нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 6г/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төв нь цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын дүрэмт хувцас, хэрэглэлээр хангах үйл ажиллагаа явуулдаг Цагдаагийн ерөнхий газрын харьяа, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төв нь Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, нэгжгүй бөгөөд дээд шатны байгууллагаас тайлант онд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 11,064,545.3 мянган төгрөгийн 1.5 хувиар буюу 165,968.2 мянган төгрөгөөр тогтоосон ба төлөвлөлтийн материаллаг байдлыг аудитын явцад дахин хянахад гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 84,386.1 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	4,924.9	5,594.7	669.8
Бараа материал	6,763,455.9	6,795,317.6	31,861.7
Үндсэн хөрөнгө	1,511,626.8	1,394,709.1	(116,917.7)
Нийт хөрөнгө	8,280,007.5	8,195,621.4	(84,386.1)
Хуримтлагдсан үр дүн	6,445,442.6	6,371,147.8	(74,294.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,280,007.5	8,195,621.4	(84,386.1)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Авлага дансны үлдэгдэл 5,594.7 мянган төгрөг болж 669.8 мянган төгрөгөөр өссөн нь оны эцэст урьдчилж төлсөн гэрэл цахилгааны төлбөрийн дүнгээр нэмэгдсэн байна. Авлага дансны үлдэгдэлд 1996-2009 онуудад үүссэн 2 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 4,924.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл бүртгэлтэй байна.

Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 31,861.7 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 190,445.4 мянган төгрөгөөр буурч бусад хангамжийн материалын үлдэгдэл 150,719.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албанаас шилжүүлэн авсан 14,990.4 мянган төгрөгийн хөрөнгийн дүнгээр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн А/85 дугаар шийдвэрээр 18,822.8 мянган төгрөгийн акталсан хөрөнгө болон тайлант оны элэгдлийн зардлын дүнгээр буурчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 74,294.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн 74,294.8 мянган төгрөгийн сөрөг үзүүлэлттэй гарсан болон засгийн газрын

капитал дансанд бүртгэлтэй 10,091.4 мянган төгрөгийн газрыг балансаас баланст шилжүүлснээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвийн 2021 оны санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,050,971.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 12,000.0 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 1,062,971.5 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Сангийн яамнаас бүтэц, орон тооны шилжилттэй холбогдуулан урсгал зардлыг 220,993.5 мянган төгрөгөөр бууруулан 841,978.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 2020 оны 4 дүгээр улиралд тус төвийн хөдөлмөрийн гэрээгээр ажиллах 30 орон тоог ЦЕГ-ын Захиргааны удирдлагын газарт шилжүүлсэнтэй уялдуулан батлагдсан төсвөөс 142,130.1 мянган төгрөгөөр бууруулан төсвийг тодотгосон байна.

Төсвийн тодотголоор зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 699,847.9 мянган төгрөгөөр санхүүжүүлж урсгалд зардалд зарцуулахаар баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 699,847.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 699,845.5 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож, үндсэн үйл ажиллагааны орлого 175,508.5 мянган төгрөг бүрдүүлсэн байна. Төлөвлөгөөнөөс 133,508.5 мянган төгрөг давсан орлогыг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Төсвийн гүйцэтгэл 694,845.5 мянган төгрөг буюу 99.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба зарцуулагдаагүй санхүүжилтийн үлдэгдэл 2,420.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70704	Цагдаа хөтөлбөр	694,627.9	694,625.5	2,420.2	99.0
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	694,627.9	694,625.5	2,420.2	99.0
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	5,220.0	5,220.0	-	100.0
Нийт дүн			699,847.9	699,845.5	2,420.2	99.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд төвийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 2 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.0 хувийн биелэлттэй, 1.0 хувь буюу 2,420.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвийн 2021 санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын явцад Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд байршуулбал зохих мэдээллийг оруулахдаа орлого, зарлагын үнийн дүн 5 сая төгрөгөөс доош бүх ажил гүйлгээ болон худалдан авалтын мэдээллийг байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 6 дугаар зүйлийн 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, мөн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалттай нийцээгүй, эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд ач холбогдолтой мэдээллийг байршуулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг дээд шатны байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд төвийн бусад үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж болон ЦЕГ-ын даргын 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/28 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам” заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүврийн байгууллагад хамрагдсан бөгөөд акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЦЕГ-ын төв байрны цайны газрын 9 ажилтан, албан хаагчдын орон тоог ЦЕГ-ын даргын 2017 оны А/221 тушаалаар Хангалт үйлчилгээний төвийн бүтэц, орон тоонд баталснаас, тэдгээр ажилтан албан хаагчдын цалин, НДШ-ийн зардал тус төвийн төсвөөс санхүүжүүлж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 18,823.7 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 13,898.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 4,924.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 4,924.9 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- ЦЕГ-ын Ахмадын санд төвлөрүүлсэн 13,229.0 мянган төгрөгийн зардлыг үр дүнгийн тайланд бараа үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан;
- Гэрэл цахилгааны зардлыг 669.8 мянган төгрөгөөр илүү төлснийг зардалд бүртгэснээс санхүүгийн үр дүнгийн тайланд зардал илүү, санхүүгийн байдлын тайланд авлага дутуу илэрхийлэгдсэн;

4.2 Албан шаардлага

Авлагын дансанд бүртгэлтэй 1996-2009 онуудад үүссэн 4,924.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Насжилт ихтэй авлага барагдуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагаас 2014-2021 оны хооронд халагдсан болон чөлөөлөгдсөн 530 албан хаагчдын эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцас, хэрэглэлтэй холбоотой төлбөр тооцоо төлөгдөөгүй, хуримтлагдсан байна. Энэ нь ЦЕГ-ын даргын 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/28 дугаар тушаалаар баталсан "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам"-ын 917.9.1-д "Цагдаагийн албанаас халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагч, ажилтнаар эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны үнийг нөхөн төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дүрэмт хувцас, хэрэглэлтэй холбоотой хуримтлагдсан төлбөр тооцоог барагдуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Байгуу лагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	ЦЕГ-ын ХҮТ	АХГ- 2022/319/ НА-СТА- ТШЗ	ЦЕГ-ын Ахмадын санд төвлөрүүлсэн 13,229.0 мянган төгрөгийн зардлыг үр дүнгийн тайланд бараа үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан	Санхүүгийн тайланд залруулах	1	13,229.0	1	13,229.0								
2	ЦЕГ-ын ХҮТ	АХГ- 2022/319/ НА-СТА- ТШЗ	Гэрэл цахилгааны зардлыг 669.8 мянган төгрөгөөр илүү төлснийг зардалд бүртгэснээс санхүүгийн үр дүнгийн тайланд зардал илүү, санхүүгийн байдлын тайланд авлага дутуу илэрхийлэгдсэн	Санхүүгийн тайланд залруулах	1	669.8	1	669.8								
3	ЦЕГ-ын ХҮТ	АХГ- 2022/319/ НА-СТА- ТШЗ	Авлагын дансанд бүртгэлтэй 1996-2009 онуудад үүссэн 4,924.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.	Албан шаардлага	1	4,924.9					1	4,924.9				
4	ЦЕГ-ын ХҮТ	АХГ- 2022/319/ НА-СТА- ТШЗ	Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагаас 2014-2021 оны хооронд халагдсан болон чөлөөлөгдсөн 530 албан хаагчдын эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцас, хэрэглэлтэй холбоотой төлбөр тооцоо төлөгдөөгүй, хуримтлагдсан байна.	Зөвлөмж	1	-									1	-
Дүн					4	18,823.7	2	13,898.8	-	-	1	4,924.9	-	-	1	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
5	ЦЕГ-ын ХҮТ	АХГ- 2022/319/ НА-СТА- ТШЗ	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд байршуулбал зохих мэдээллийг оруулахдаа орлого, зарлагын үнийн дүн 5 сая төгрөгөөс доош бүх ажил гүйлгээ болон худалдан авалтын мэдээллийг байршуулсан байна.	Зөвлөмж	1	-									1	-
Дүн					1										1	-
Нийт дүн					5	18,823.7	2	13,898.8	-	-	1	4,924.9	-	-	2	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 01/А0160057
АХГ-2022/319/НА-СТЭ-ТМЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Авлагын дансанд бүртгэлтэй 1996-2009 онуудад үүссэн 4,924,869.10 төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг барагдуулах, зөрчлийг арилгах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвийн дарга А.Энхбат, ахлах нягтлан бодогч Ш.Одонгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.ХОСЖАРГАЛ

АХЛАХ АУДИТОР

Л.НЯМТӨМӨР



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherreg\Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-1.Docx

001080001